



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 12 дугаар сарын 02

№ 01/25

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ  
ТАНАА

Нийслэлийн [redacted] дүүргийн иргэн [redacted] Комисст хандаж “Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт удаа дараа бичгээр хүсэлт гаргасан боловч миний хүсэлтийг бүрэн шийдвэрлэхгүй Үндсэн хуулиар баталгаажсан төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гаргах, шийдвэрлүүлэх эрх зөрчигдөж байна” гэх гомдлыг ирүүлжээ.

Гомдлын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтнаас гомдол гаргагчид албан бичгээр өгсөн хариу, иргэн А.Базараас авсан нэмэлт тайлбар, холбогдох эрх зүйн зохицуулалтыг судлахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Иргэн [redacted] 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хандаж дараах 5 мэдээллийг хүссэн байна. Үүнд:

1. Албадан чөлөөлж, явган хүний болон дугуйн зам барих тухай А/551 дүгээр захирамжийн хуулбар;
2. Оргил худалдааны төвийн зүүн талд байрлах нийтийн эзэмшлийн талбайн газарт дугуйн зам тавихтай холбоотой шийдвэр гарсан эсэх, гарсан бол шийдвэрийн хуулбар;
3. Тус газарт дугуйн зам тавих ажил явагдах эсэх мэдээлэл;
4. Тус газарт нийт хэдэн м.кв газар чөлөөлсөн тухай мэдээлэл;
5. Тухайн газрыг чөлөөлөх тухай мэдэгдэл, шийдвэр гарсан эсэх, гарсан бол тус мэдэгдэл, шийдвэрийн хуулбар.

Түүний энэхүү хүсэлтийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч [redacted] дээрх байршилд хийгдэж буй бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг тус иргэнд хүргүүлж ажиллах тухай 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 06/2810 дугаар албан бичгийг “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын дарга [redacted], хүргүүлжээ. “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ дээрх албан бичгийн дагуу иргэн [redacted] мэдээллийг гаргаж хүргүүлээгүй бөгөөд энэ нь иргэн [redacted] Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчсөн гэж үзэж байна.

2. Иргэн [redacted] 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт дахин хүсэлт гаргахад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөншагай “Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/551 дугаар захирамжаар

150060072



Нийслэлийн [redacted] дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэр, [redacted] худалдааны төвийн зүүн талд байрлах нийтийн эзэмшлийн зам талбайд явган хүний замыг стандартад нийцүүлэн, барьж ашиглалтад оруулсан бөгөөд дээрх шийдвэртэй холбоотойгоор харьяалах шүүхэд хэрэг маргаан үүссэн талаарх мэдээлэл манайд байхгүй байна. Мөн манай байгууллагаас "Улаанбаатар зам засвар арчлалтын газар" ОНӨААТҮГ-т хүргүүлсэн 2022 оны 06/2810 дугаар албан бичгийн хариу, тухайн байршилд унадаг дугуйн замын ажил хийгдэх эсэх талаарх мэдээллийг тухайн байгууллагаас танд хүргүүлж ажиллах чиглэл өгсөн болно" гэх хариуг 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 06/4200 дугаар албан бичгээр хүргүүлсэн хэдий ч түүний хүссэн мэдээлэл буюу 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/551 дугаар "Газар албадан чөлөөлж, явган хүний болон дугуйн зам барих тухай" захирамжийн хуулбар болон холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй байна. Дээрх асуудлаар [redacted] нь 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Хүний эрхийн үндэсний комисст хандан мэдээлэл авах эрх зөрчигдөж байгаа талаар гомдол гаргасны дагуу Комиссоос ажиллагаа явуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Содбаяр "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 323 дугаар албан бичиг болон Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/551 дугаар захирамжийн хуулбарыг 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 06/4750 дугаар албан бичгээр иргэн А.Базарт хүргүүлсэн байна.

3. Иргэн [redacted] Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч [redacted] 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 06/4750 дугаар албан бичгээр түүнд хүргүүлсэн "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ-ын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 323 дугаар албан бичиг болон Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/551 дугаар захирамжийн хуулбартай холбогдуулан 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хандаж дараах 3 мэдээллийг нэмэлтээр хүссэн байна. Үүнд:

1. Оргил худалдааны төв нь нийт хэдэн м.кв талбай газрыг хууль бусаар ашиглаж байснаас хэдий талбай бүхий газарт явган хүний зам тавьсан талаарх мэдээлэл баримт;
2. Ямар байгууллага, компаниас хэнд хүсэлт гаргаж, хэн гэдэг албан тушаалтан тийнхүү дугуйн зам тавихгүй байх шийдвэр гаргасан болохыг мэдэх, энэ талаарх шийдвэрийн хуулбар;
3. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/551 дугаар захирамжид өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон захирамж, шийдвэр, тогтоол гарсан эсэх талаар мэдээлэл.

Түүний энэхүү хүсэлтэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч [redacted] 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 06/4919 дугаар албан бичгээр "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь хэсэгт "төрийн тухайн байгууллага, албан тушаалтанд иргэн өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, гомдол гаргасан бөгөөд түүнийг дахин хянаж шийдвэрлэх үндэслэлгүй" гэж заасны дагуу дахин хянан үзэх боломжгүй байна" гэх хариуг өгчээ.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч [redacted] дээрх үйлдэл нь иргэний гаргасан хүсэлтийг бүрэн ойлгоогүй, төрийн албан хаагчийн мэргэжлийн бэлтгэгдсэн



байдал, төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд эргэлзээ төрүүлэхээс гадна иргэний Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчсөн гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт Монгол Улсын иргэн "... төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй", мөн зүйлийн 17 дахь хэсэгт "... төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй" гэж үндсэн эрхийг баталгаажуулсан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт "хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана" гэж заасан.


Түүнчлэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилго бүхий Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг Монгол Улсын Их хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөгдөж байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах Шаардлагыг хүргүүлж байна. Үүнд:

1. Иргэн [redacted] хүсэлтэд дурдсан мэдээллийг нэн даруй гаргаж хүргүүлэх;
2. Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчсөн холбогдох албан тушаалтанд хуульд заасан үндэслэл журмын дагуу хариуцлага тооцох;
3. Төрийн албаны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хууль болон хүний эрх, эрх чөлөө, иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын алба хаагчдыг сургалтад хамруулах;

Шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 14 хоногийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Ж.ХУНАН